

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2022.04.29

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 7 дугаар хуралдааныг зохион байгуулж 6 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газрын 3 албан хаагчийг төрийн худалдан авах ажиллагааны А-3 сургалтад хамруулж, 2 албан хаагч худалдан авах ажиллагаанд оролцох эрх авсан.

Аймгийн ЗДТГ, агентлагуудаас зохион байгуулсан “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем”, ХАБЭА-н ажилтан мэргэшүүлэх, орон нутгийн хөгжлийн сан, санхүү, төрийн сангийн ажилтны сургалтуудад 9 алба хаагч хамрагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2022 сарын аяны захирамж, хөтөлбөрийг суманд хэрэгжүүлэх ажлын хэсгийг сумын засаг даргын А/33 дугаар захирамжаар томилон, төлөвлөгөө, удирдамжийг батлуулан, байгууллага, ААН-ийн удирдлагад хүргэж, хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмжөөр хангаж ажилласан. Аяны хүрээнд хийсэн ажлын нэгдсэн тайланг аймгийн ХАБЭА-н ажлын хэсэгт хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлт 82.6 хувьтай хэрэгжсэн.

Улаанбаатар дахь нутгийн зөвлөлийн төлөөлөгчид ирж ажлын төлөвлөгөө, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлыг танилцуулж, суманд шинээр байгуулагдах “Цэцэрлэгт хүрээлэн”-гийн ажлын зураг, тооцоо, судалгааг танилцуулж ажлыг 05 дугаар сард эхлүүлэхээр болсон.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.


Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан Үндэсний хэл бичгийн өдрийг тэмдэглэх ажлын төлөвлөгөөг гарган төрийн албан хаагчдын монгол бичгийн түвшинг тогтоон ЗДТГ, ЕБС, цэцэрлэгийн албан хаагчид сургалтад хамрагдаж байна.

Аймгийн засаг даргаас сумын засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, албан байгууллага, ААН, үйлчилгээний газруудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдүүлэх, тохилог, цэвэр орчинг бүрдүүлэх, төрийн албан хаагч, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, шинэ санаачлагыг сурталчилан орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор “Тохилог орчин-Хөгжлийн эхлэл” уралдааныг 04 дүгээр сарын 20-ноос 06 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж байна.



Засаг даргын тамгын газар, цагдаагийн хэсэг, ЕБС хамтран ахлах ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэргээс өөрийгөө хамгаалах сургалтыг хамтран зохион байгуулсан./98 сурагч хамрагдсан/

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын зорилтот бүлгийн сургалт хариуцсан багш Э.Насанжаргал хүүхдийн эрх хамгаалах мэргэжилтэн Э.Оюунзул, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, сэтгэл зүйч О.Алтанчимэг

нарыг урьж “Хуримтлал ба зардал, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Гэр бүлийн харилцаа” сэдвээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.



Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Багш нарын ур чадварыг сайжруулах, хосолсон сургалтын арга зүй болон идвэхтэй аргуудыг ашиглан хичээл заах чадвар эзэмшилтийг шалгаруулах “САЙН БАГШИЙН-САЙН ТЕХНОЛОГИ” уралдааны I шатыг зохион байгуулсан.



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2022” аяны хүрээнд сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжиж байгаа хүүхэд, ажилтан албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд сурч, ажиллах орчинг бүрдүүлэх, хууль дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор ЕБС, СӨБ-ийн байгууллагад хийгдэж байгаа ажлыг олон нийтэд сурталёилах, таниулах “Өдөрлөг”-ийг хамтран зохион байгуулж дараах үйл ажиллагааг хүргэв:

- Багш, ажилчид, сурагчдын ажлын байрны дасгал, хөдөлгөөн /ЕБС, цэцэрлэг/
- Гар урлалын төрөл ашиглан сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг хэрэглэгдэхүүний танилцуулга, үзэсгэлэн

- Ажлын байрны болон дүрэмт хувцасны үзүүлбэр, танилцуулга
- Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, мэдээлэл
- Хүүхэд хамгалал, түүний талаарх мэдээлэл
- Эцэг, эх асран хамгаалагчийн систем, бүртгэлийн мэдээлэл
- Сурагчдын үдийн хоол, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ, илчлэг, шим тэжээлийн талаарх танилцуулга, амталгаа явагдав./160 гаран эцэг, эх хамрагдсан/



Мөн дээрх аяны хүрээнд сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор жолооч нарыг тухайн бүсэд зорчихдоо замын хөдөлгөөний дүрмийг мөрдөхийг анхааруулсан “Шар дарцаг” байрлуулж, өдөр бүр эцэг, эхчүүд, байгууллагын ХАБЭА-н ажлын хэсгээс ээлжийн хуваариар томилогдон ажиллаж байна.



Өсвөр үеийн Хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Баруун урт хотод зохион байгуулагдаж тус сумын багш, сурагчид амжилттай оролцон багаараа I байрт шалгарсан.

Хүүхэд багачуудын чөлөөт сэтгэлгээ, авьяас чадварыг нээх, хөгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцож өөрийгөө илэрхийлэх чадварт суралцуулах зорилгоор мэргэжлийн байгууллага, салбаруудаас 04 дүгээр сард зохион байгуулсан эссэ бичлэг, гар зураг, ханын сонин урлалын уралдаанд тухай бүр нь сурагчдыг хамруулж, амжилтыг нь ахиулсан.

“Писа-2022 олон улсын амжилтын үнэлгээ”-ний шалгалтад тус сургуулийн 10А бүлэг сонгогдож амжилттай дүгнэгдэв.

Цэцэрлэгийн багш нарын заах аргыг сайжруулах, багш хүүхдийн харилцааг нээлттэй болгох “Сайн багш-Сайн үйл ажиллагаа” нээлттэй хичээлүүд, хэлэлцүүлгийг зохион байгуулав.



Эцэг, эхийн хурлыг зохион байгуулж, хүүхдэд олгож байгаа хоолны орц, төрөл, хүүхдээ хоолоо идсэн эсэхийн мэдээллийг хүссэн үедээ авах ESIS апплейкшнийг танилцуулж хэрхэн ашиглах зааварчилгааг өгөх, эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, цэцэрлэгт шинээр хийгдэх ажлаа танилцуулсан.

Салбар цэцэрлэгийн багш, ажилчид бяцхан сурагчиддаа малчны хөдөлмөр, төл талыг таниулах “Малчны хотонд аялацгаая” аялал зохион байгуулав.



“Сүхбаатар-80” урлагийн наадмын бэлтгэл ажилд хөгжмийн найруулагч, бүжгийн багш ажилуулах, тоглолтын хувцас шинээр хийлгэхэд 3.694.000 төгрөг зарцуулсан.

Аймгийн нийтийн номын сангаас шинэ ном авч фондод баяжилт хийсэн. Дэлхийн номын өдрийн хүрээнд номын санч, мэдээллийн ажилтнуудын дунд “Номын сан, мэдээллийн ажилтан мэдээллийн боловсрол олгогч болох нь” сэдэвт цахим хэлэлцүүлэгт соёлын төв, ЕБС-ийн номын санчдыг оролцуулсан.

Номын өдрийг тохиолдуулан хилийн 0184 дүгээр ангиас зохион явуулсан “Номын өдөрлөг”-т оролцож, сумын номын сангийн танилцуулгыг хийж, шинэ номын мэдээлэл хүргэсэн.




Соёлын төвийн дэргэдэх “Үүлэн” бүжгийн дугуйлан нь 04 дүгээр сарын 11-ээс 8 хүүхэдтэй хичээллэж эхэлсэн.

Соёл урлагийн газраас ирүүлсэн “Зөв зөвд шударга зөв” уриалгыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргэсэн.

Эмч нарын өдрийг тохиолдуулан сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Эмч мэргэжил-Бидний бахархал” тэмцээнийг зохион байгуулж, 5 баг, 25 хүн оролцсон.

Хөдөлмөрийн аюулүй байдал, эрүүл ахуй-2022 аяныг захирамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, байгууллага бүр ажлын хэсэг байгуулан ХАБЭА-н чиглэлээр олон талт ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Засаг даргын тамгын газрын ажлын хэсгээс байгууллага бүрийн эрсдэлийг үнэлгээний хуудсаар үнэлж, дүн шинжилгээ хийж, холбогдох албан хаагчдад дүнг танилцуулсан.

Засаг даргын тамгын газрын 2 давхар дахь хэсгийг засварлан албан хаагчид ажлын алжаалаа тайлах амралтын хэсэг болгон тохижуулж мөн иргэдэд төрийн үйлчилгээ авах тухтай орчинг бүрдүүлэв.



Тамгын газрын нийгмийн даатгалын байцаагч “Үйлдвэрлэлийн ослын даатгал” сэдвээр цэцэрлэг, ОНӨҮГ-т сургалт, зөвөлгөөг өгсөн.



Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Мал эмнэлгийн тасгаас шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын 3 бүлэг хөдөөгийн багуудад ажиллаж байна.

Сумын засаг даргын захирамжаар нохой устгал, сэг зэм арилгах, их цэвэрлэгээ хийх ажлуудыг сумын төвд зохион байгуулж, 79 нохой устган, төрийн албан хаагчид, халамжид хамрагддаг иргэд их цэвэрлэгээний ажлыг 04 дүгээр сарын 21-25 өдрүүдэд хийж эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлсэн.



“Хүрээлэн байгаа орчинд ээлтэй аялал жуулчлал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт улсын зөвөлгөөнд ЗДТГ-ын байгаль хамгаалагчийг оролцуулсан.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ